



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Л.МӨНХБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025. 10. 02 № ХЯГ/2742
танай _____-ны № _____-т

Асуултын хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолд тусгагдсан “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ.” тэргүүлэх чиглэлийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуултын хүрээнд дараах хариуг хүргүүлж байна.

1.“Цомхон, чадварлаг, бүтээмжтэй” төрийн албыг төлөвшүүлж, төрийн албаны шинэчлэлийг эрчимжүүлэх зорилтын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 51 дүгээр захирамжаар Төрийн албаны шинэчлэлийн Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцох аргачлалыг боловсронгуй болгох, ил тод, нээлттэй байдлыг хангах, төрийн албаны сургалтын тогтолцоог сайжруулах, төрийн албаны цахимжилтыг эрчимжүүлэх болон төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын дэд хэсгүүдийг мөн байгуулан ажиллаж байна.

2.Монгол Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах, төрийн албан хаагчдын тоог (багш, эмч нараас бусад) 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх зорилтыг тусгасан. Уг зорилтын хүрээнд төрийн албаны орон тоог бууруулахдаа төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээнд үндэслэж, удирдах, гүйцэтгэх албан тушаалын зохистой харьцааг хангах, чиг үүргийн давхардлыг арилгах, төсөв, зардлыг хэмнэх, төрийн үйл ажиллагааг цахимжуулах арга хэмжээг авч, яам, Засгийн газрын агентлаг болон бусад төрийн байгууллагын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг зогсоох, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгож, орон тоог нэмэгдүүлэхгүй байхын зэрэгцээ өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байх зэрэг шалгуурыг баримтлан ажиллаж байна.

3.“Оновчтой бүтэц, орон тоо” гэж чиг үүргийн давхардалгүй, удирдах, гүйцэтгэх түвшний зохистой харьцаа тогтсон, үндсэн болон нийтлэг чиг үүргийн нэгжийн эзлэх хувийг зөв тодорхойлохыг хэлэх бөгөөд төрийн байгууллагын оновчтой бүтэц, орон тоог тогтоох чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас яамд, Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлаад байна.

Өнөөдрийн байдлаар Яамдын шинэ зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтөөр нийт 28 газар, 53 хэлтсийг татан буулгасан. Тодруулбал, удирдах албан тушаалын 81, гүйцэтгэх албан тушаалын орон тоо 87, нийт орон тоо 168-аар буурсан. Ингэснээр цалин хөлсөд зарцуулах хөрөнгө, жилд 6.3 тэрбум төгрөгөөр хэмнэгдэхээр тооцсон байна.

000255002395

Төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлж буй 5 тохируулагч агентлагаас бусад 35 Засгийн газрын агентлагийн зохион байгуулалтын бүтцэд нийт 148 газар, 173 хэлтэс, алба байсан бөгөөд агентлагуудын удирдлага, зохион байгуулалтын ерөнхий бүтэц, газар, хэлтсийн тооны харьцаа, нэршил, бүтцийн нэгжид ногдож буй орон тооны мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр зохион байгуулалтын бүтцийн нэгжийн тоо, нэршлийг тогтоож, "Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар тогтоолыг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Уг тогтоолыг хэрэгжүүлснээр Засгийн газрын агентлагийн нийт орон тоо 301-ээр, үүнээс газар, хэлтэс, албаны даргын орон тоо 54-өөр буурах бөгөөд цалин хөлсний зардал жилд 10 орчим тэрбум төгрөгөөр хэмнэгдэх боломж бүрдэнэ.

Түүнчлэн Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан нийт 57 үндэсний хороо, комисс, зөвлөл ажиллаж байсан. Үүнээс ажлын албатай 12 үндэсний хороо, зөвлөлийг татан буулгаж 146 орон тоо, 41.6 тэрбум төгрөгийн зардал хэмнэгдэж байна.

4.Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд туссан дээрх зорилтыг үе шаттай хэрэгжүүлэхээр 2025 оны төсвийн тодотголд төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулахаар тооцож, төрийн тусгай албаны орон тоог 1.5 мянгаар, төрийн захиргааны албаны орон тоог 2.9 мянгаар, төрийн үйлчилгээний орон тоог (багш, эмч нараас бусад) 8.2 мянгаар, төрийн улс төрийн орон тоог 0.2 мянгаар тус тус бууруулсан.

Төрийн албаны орон тоог бууруулах ажлыг төрийн үйл ажиллагааны салбар болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр биш, харин төсвийн ерөнхийлөн захирагчдын харьяа байгууллагуудад сул байгаа орон тоо, тэтгэвэрт гарахаар 2025 оны төсөвт тэтгэмжийн зардал нь туссан албан хаагчийн оронд нөхөн томилгоо хийлгүйгээр, ажлын байрны чиг үүрэг, бүтээмжийн үнэлгээнд тулгуурлан харьяалах төсвийн захирагчдын хооронд орон тооны зохицуулалт хийн зохион байгуулж байна.

Орон тоо буурахтай холбоотойгоор нэгдсэн төсвийн цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын оны сүүлийн хагас жилийн төсвийн нөлөөлөл 260.5 тэрбум төгрөгөөр буурч байна.

Сүүлийн 10 жилд дунджаар нийт төрийн албан хаагчдын 68 хувийг төрийн үйлчилгээ, 20.5 хувийг төрийн тусгай, 9.8 хувийг төрийн захиргаа, 1.7 хувийг төрийн улс төрийн албан хаагчид эзэлж байна. Эндээс үзэхэд, төрийн албан хаагчдын тооны дийлэнх хувийг төрийн үйлчилгээний албан хаагчид эзэлж байна. Нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлтийг дагаж төрийн үйлчилгээний багш, эмч, сувилагч нарын тоо зайлшгүй нэмэгддэг зүй тогтолтой байдаг. Цаашид төрийн захиргаа, төрийн улс төрийн, төрийн үйлчилгээний албаны зарим хэсэгт бүтэц, орон тоог оновчлох ажлыг үргэлжлүүлж, тогтсон, зохистой харьцааг бий болгохоор зорьж байна.

Хавсралт  хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2025.09.23 № 02/8704

танай _____-ны № ХЭГ/2532 -т

Хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангаас төрийн албаны реформын талаар ирүүлсэн асуулттай танилцлаа.


Монгол Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, төрийн албан хаагчдын тоог (багш, эмч нараас бусад) 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх зорилтыг тусгасан.

Зорилтыг үе шаттай хэрэгжүүлэхээр 2025 оны төсвийн тодотголд төрийн албан хаагчдын орон тоог /багш, эмчээс бусад/ 9 хувь бууруулахаар тооцож нийт 12.9 мянгаар бууруулсан. Үүнээс төрийн тусгай албан хаагчийн орон тоог 2.8 мянгаар, төрийн захиргааны орон тоог 2.9 мянгаар, төрийн үйлчилгээний орон тоог /багш, эмчээс бусад/ 8.4 мянгаар, улс төрийн орон тоог 0.2 мянгаар тус тус хасахаар тооцсон.

Орон тоо буурахтай холбоотойгоор нэгдсэн төсвийн цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын оны сүүлийн хагас жилийн төсвийн нөлөөлөл 260.5 тэрбум төгрөгөөр буурч байна.

Орон тоог бууруулах ажлыг төсвийн ерөнхийлөн захирагчдын харьяа байгууллагуудад сул байгаа орон тоо, тэтгэвэрт гарахаар 2025 оны төсөвт тэтгэмжийн зардал нь туссан албан хаагчийн оронд нөхөн томилгоо хийлгүйгээр, ажлын байрны чиг үүрэг, бүтээмжийн үнэлгээнд тулгуурлан харьяалах төсвийн захирагчдын хооронд орон тооны зохицуулалт хийн зохион байгуулж байна.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ

9766015249



МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСАГ ХӨГЖЛИЙН ЯАМ

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2025.10.01 № 02/2709

танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан төрийн албаны реформтой холбоотой асуултын хүрээнд дараах хариуг хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд төрийн албаны шинэчлэлийг гүнзгийрүүлж, чиг үүргийн давхардлыг арилгах замаар төрийн албан хаагчдын тоог багш, эмч зэрэг нийгмийн үйлчилгээний зайлшгүй шаардлагатай салбараас бусад хэсэгт 9 хувиар бууруулах зорилт тусгагдсан. Энэ арга хэмжээний гол зорилго нь илүүдэл бүтэц, орон тоог бууруулж, төсвийн үр ашгийг дээшлүүлэн, чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг төлөвшүүлэхэд чиглэж байна.

Бүтэц, орон тоог бууруулах нь төрийн байгууллагын бүтцийг оновчтой болгох, чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах болон гүйцэтгэх албан тушаалын харьцааг зохистой болгох, төсвийн хэмнэлт бий болгох зэрэг олон талт бодлогын арга хэмжээ юм. Энэ хүрээнд үйлчилгээний хүртээмж, чанарыг бууруулахгүй байх зарчмыг баримталж байгаа бөгөөд орон нутгийн хэрэгцээ, нийгмийн үйлчилгээний ачааллыг заавал харгалзан үзэх шаардлагатай.

Төрийн албаны шинэчлэлийн талаарх олон улсын туршлагаас харахад Эстонид төрийн үйлчилгээг цахимжуулснаар төрийн зардлыг бууруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулсан бөгөөд иргэдийн сэтгэл ханамж 83.0 хувь болж нэмэгдсэн нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын дунджаас 20.0 орчим хувиар илүү гарч олон улсын байгууллагууд үүнийг амжилттай туршлага гэж үнэлсэн (OECD, 2025). Мөн Гүрж Улсад 2004 онд төрийн албыг 41.0 хувиар цомхотгож, авлигын түвшнийг огцом бууруулсан бол Канад Улс 1990-ээд онд "Program Review" хөтөлбөрөөр таван жилийн дотор 25.0 тэрбум канад долларын төсвийн хэмнэлт гаргасан байна. Мөн Малайзад "Засгийн газрын шинэчлэлийн хөтөлбөр (GTP)"-өөр давхардсан бүтцийг танаснаар үйлчилгээний хугацаа багасаж, төрийн үйлчилгээний чанар сайжирсан байна.

Олон улсад төрийн албаны шинэчлэл зөв хэрэгжсэн тохиолдолд төсөв, бүтээмж, үйлчилгээний чанарт эерэг нөлөө үзүүлж, мөн төрийн албаны өөрчлөлтийн хүрээнд төрийн үйлчилгээний зарим чиглэлд хувийн хэвшил болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлснээр хүнд суртлыг багасгах хөшүүрэг болдог. Тухайлбал, Латин Америкийн орнууд төрийн чиг үүргийг бууруулж, хувийн хэвшилд шилжүүлэх арга хэмжээг төрийн албаны бүтэц, орон тоог бууруулахтай уялдуулж хэрэгжүүлсэн байдаг (UNDP, 2011).

152863062040

Монгол Улсад 2024 оны байдлаар нийт 226,895 төрийн албан хаагч ажиллаж байгаагаас 67.3 хувийг төрийн үйлчилгээний, 21.6 хувийг төрийн тусгай, 9.4 хувийг төрийн захиргааны, 1.7 хувийг улс төрийн албан хаагчид эзэлж байна (ҮСХ, 2024). Энэ нь нийт ажиллагчдын 16.5 хувийг бүрдүүлж байгаа нь өндөр хөгжилтэй зарим орнуудаас доогуур боловч бүс нутгийн хэмжээнд харьцангуй өндөр үзүүлэлт байна. Сүүлийн 12 жилд төрийн тусгай албан хаагчдын тоо хамгийн их буюу 70.5 хувиар, улс төрийн албан хаагчдын тоо 36.6 хувиар нэмэгдсэн бол үйлчилгээний болон захиргааны албан хаагчдын өсөлт хүн амын тооны өсөлттэй уялдсан, харьцангуй тогтвортой хэвээр байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4 дэх заалтад "төрийн албаны хүний нөөцийн асуудал" нь Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар заасан тул төрийн албаны реформтой холбоотой илүү нарийвчилсан мэдээллийг танай газраас бэлтгэн хүргүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

